



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар АМД

Бсэлбулаг

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 35.000.000 (гучин таван сая) төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэ сумын Цагаан-Уул багт худаг гаргах ажлыг гүйцэтгүүлэх эрхийг Эрдэнэ сумын Засаг дарга (Э.Давааням)-д шилжүүлсүгэй.

2. Төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт болон бусад шаардлагатай мэдээллийг 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор боловсруулан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Эрдэнэ сумын Засаг дарга (Э.Давааням)-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

